

Коронавирусын вакцины

4 дэх тунд хамрагдах тухай мэдэгдэл

4



Вакцин хийлгэх төлбөр Үнэ төлбөргүй

Засгийн газраас бүрэн санхүүжүүлнэ

4 дэх тунг хийлгэх боломжтой боллоо.

4 дэх тунг хийлгэснээр хүндрэдээс урьдчилан сэргийлэх өндөр үр дүнтэй.



Хэн вакцин хийлгэх боломжтой

Энэ үеийн шинжлэх ухааны мэдээллүүд зэрэгт үндэслэн дараах хүмүүст 5 дугаар сарын сүүлээр 4 дэх тунг хийж эхэлнэ.



*Хамсарсан өвчний тухай (зөвхөн Япон)

3 дахь тунг хийлгэснээс хойш 5 сарын хугацаа өнгөрсөн

① 60-с дээш настай ② 18 ба түүнээс дээш настай, суурь өвчтэй хүмүүс

Бусад хүндрэх эрсдэл өндөртэй хүмүүс

※ ①-д хамаарах хүмүүс оршин суугаа газрын хотын захиргаанаас илгээх вакцины тасалбарыг вакцин хийлгэх газарт авч очоорой.

※ ②-т хамаарах эсэх тухайд, Суурь өвчтэй зэрэг шалтгаанаар эмнэлгийн байгууллагад үзлэгт хамрагдсан болон урьдчилан зөвлөгөө авдаг эмнэлэгтэй хүмүүс нь тухайн эмнэлгийнхээ эмчтэй зөвлөлдөөрэй. Урьдчилан зөвлөгөө авдаг эмнэлэггүй хүмүүс нь вакцин хийлгэх газрын урьдчилсан үзлэгийн үед зөвлөгөө аваарай. Тасалбар хэрхэн тараах талаарх мэдээллийг оршин суугаа газрын хотын захиргаанаас лавлаарай.

①②-с бусад хүмүүст зориулсан 4 дэх тунгийн талаар цаашид үргэлжлүүлэн төрөл бүрийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх болно.

Хэрэглэх вакцин

1-3 дахь тунд хийлгэсэн вакцины төрлөөс үл хамааран, Pfizer болон Takeda/Moderna компаниудын вакциныг хэрэглэнэ.

Коронавирусын вакцины

Үр дүн

- Гадаадад хийсэн судалгаагаар 3 дахь тунг хийлгэснээс хойш 4 сарын хугацаа өнгөрсөн 60 ба түүнээс дээш насны хүмүүст Pfizer компанийн вакциныг 4 дэх тун болгон хийхэд, омикрон омгийн тархалтын хувьд тариулснаас хойш 6 долоо хоногийн хугацаа өнгөрсөн ч өвчний шинж тэмдэгээс урьдчилан сэргийлэх үр дүн нь багасаагүй үргэлжилж байгааг мэдээлсэн.

Эх сурвалж : Bar-On YM et al. Protection by a Fourth Dose of BNT162b2 against Omicron in Israel. NEJM. 2022.

Коронавирусын вакцины

Аюулгүй байдал

- Гадаадад хийсэн судалгаагаар 4 дэх тунг хийлгэсний дараа 21 хоног болоход ямар нэгэн ноцтой гаж нөлөө илрээгүй гэж мэдээлсэн.

□ 18 ба түүнээс дээш насныханд вакцин хийсний дараа 21 хоногт илэрсэн шинж тэмдэгүүд

50% дээш	Өвдөлт 78.8%
10 - 50%	Ядрах 33.2% Булчин өвдөх 24.5% Толгой өвдөх 21.5% Хавдах 12.0%
1 - 10%	Үе мөч өвдөх 8.4% 37.5-с дээш халуурах 6.6% Тунгалагийн судас хавдах 4.7% Улайх 8.0% Мэдрэхүйн бэрхшээл 1.5% Харшил өгөх 1.0%

(※) Судалгаанд: 274 хүн (Pfizer компани: 54 хүн, Moderna компани: 120 хүн)

Эх сурвалж : Gili Regev-Yochay et al. Efficacy of a Fourth Dose of Covid-19 mRNA Vaccine against Omicron. NEJM. 2022.

◎ Оршин суугчийн бүртгэл (оршин сууж буй газар) -ын дагуу бүртгэлтэй газраас бусад газарт вакцин хийлгэх

- Хэрэв та вакцинаа эрүүл мэндийн байгууллага эсвэл халамжийн байгууламжид хийлгэвэл
→ **тухайн эрүүл мэндийн байгууллага эсвэл халамжийн байгууламжаас зөвлөгөө аваарай.**
- Хэрэв та суурь өвчний улмаас эмчлүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагад вакцин хийлгэвэл
→ **тухайн эрүүл мэндийн байгууллагаас зөвлөгөө аваарай.**
- Хэрэв таны оршин сууж буй газар таны үндсэн хаягаас өөр бол
→ **та вакцинаа амьдардаг газартаа хийлгэж болно.**

Оршин суугаа хот, дүүргийнхээ вэбсайтыг шалгах эсвэл таны амьдардаг хотын захиргааны зөвлөх албатай холбоо бариарай.

◎ Вакцинжуулалтад хамрагдахын тулд таны зөвшөөрөл шаардлагатай.

Вакцин хийлгэхдээ халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үр нөлөө болон гаж нөлөөний эрсдэлийн талаар зөв мэдлэгтэй байж, тухайн хүний хүсэлд тулгуурлан вакцин хийлгэх шийдвэрийг гаргахыг зөвлөж байна. Вакцин хийлгэх хүний зөвшөөрөлгүйгээр вакцин хийх боломжгүй.

Ажлын байрны эргэн тойрны хүмүүс зэрэгт албадан вакцин хийж мөн вакцин хийлгээгүй хүмүүсийг гадуурхаж огт болохгүй.

◎ Вакцинаас үүдэх эрүүл мэндийн хохиролд үзүүлэх тусламжийн тогтолцоо байдаг.

Вакцин нь эрүүл мэндэд хохирол (өвдөх, хөгжлийн бэрхшээлтэй болох г.м.) учруулах магадлалтай. Нэн ховор тохиох боловч үүнийг бүрэн арилгах боломжгүй учир тусламжийн тогтолцоо байдаг.

Өргөдөлд шаардлагатай процедурын талаар оршин суугчийн бүртгэлтэй хотын захиргаанаас лавлана уу.

Вакцин хийлгэсний дараа ч мөн маскаа зүүж, халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсаар байхыг зөвлөж байна.

Коронавирусын вакцин нь коронавирусын халдвар үүсэхээс урьдчилан сэргийлэх өндөр үр дүнтэй болох нь батлагдсан ч үр дүн нь 100 хувь биш юм. Мөн вирусын өөрчлөлтөөс хамаарах нөлөө ч байна.

Иймээс та бүхнээс халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээгээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үндсэндээ “3 нягт (бөөгнөрөх, ойр байх, битүү орчин)”-аас зайлсхийх, амны хаалтаа зүүх, гараа савандаж угаах болон спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгчээр гараа ариутгах зэрэг дадлыг хэрэгжүүлэхийг зөвлөж байна.


Халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээгээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг зөвлөж байна.



Бөөгнөрсөн байрлал



Ойртох



Агааргүй битүү орчин

“3 нягт (бөөгнөрөх, ойр байх, битүү орчин)”-аас зайлсхийх



Амны хаалтаа зүүх



Гараа савандаж угаах



Спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгчээр гараа ариутгах

Хэрэв та вэбсайт үзэх боломжгүй бол оршин суугаа хотын захиргаа руу хандана уу.

Коронавирусын вакцины үр нөлөө, аюулгүй байдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны вэбсайт дахь “Шинэ төрлийн коронавирусын вакцин” хуудаснаас үзнэ уу.

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Корона Вакцин

Хайх

